

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ГҮЙЦЭТГЭХ, ҮР ДҮНГ ТООЦОХ ЖУРАМ

/Шинэчилсэн найруулга/

2017.11.20

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлд тус тус заасан улсын төсвийн хөрөнгө (цаашид “УТХ” гэх)-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, батлагдсан төсвийг хуваарилах, санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээ гаргах, үр дүнг хүлээн авах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам нь Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын хүрээнд зохицуулагдана.

1.3. Геологийн судалгааны ажил (цаашид “ГСА” гэх)-д Ашигт малтмалын тухай хуулийн 11¹ дүгээр зүйлд заасан геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуул хийх, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах зэргийг хамруулж ойлгоно.

1.4. Геологийн судалгааны ажилд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн ерөнхийлөн захирагч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд (цаашид “сайд” гэх) байна.

Хоёр. Геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх

2.1. Геологийн судалгааны ажлын төлөвлөх, батлуулах

2.1.1. ГСА-ыг гүйцэтгэхэд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу бүс нутгийн хөгжлийг жигд хангах зорилгоор геологийн тогтоцыг нарийвчлан судлах, давхраажсан хурдас, гүний чулуулгийг ангилах, нас тогтоох, металлогений муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг бүрхэх, дэлхийн болон бүс нутаг, улс орны зах зээл дээр стратегийн ач холбогдолтой эрдэс түүхий эдийг богино хугацаанд бага зардлаар судлан, үр дүнд хүрэх зарчмыг баримтлана.

2.1.2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) нь дараа онд УТХ-өөр шинээр гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага,

эрдэмтэд, их, дээд сургуулиас саналыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор авч энэхүү журмын 2.1.3-д заасан төлөвлөгөөний төсөлд тусгана.

2.1.3. Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.1.1-д заасан зарчмыг баримтлан дараа онд гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөний төслийг 1, 2 дугаар хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (цаашид “ЭБМЗ” гэх)-өөр хэлэлцүүлэн 3 дугаар сарын 10-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх)-д хүргүүлнэ.

2.1.4. Төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор дараа онд гүйцэтгэх ГСА-ын төсөв, төлөвлөгөөний төслийг хянан нэгтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Сангийн яам” гэх)-д хүргүүлж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгуулна.

2.1.5. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд-төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн-санхүүгийн жилийн төсвийн багц батлагдсаны дараа төлөвлөгөөт онд гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөө, төсвийг төсөл тус бүрээр боловсруулан төрийн захиргааны байгууллагын саналыг тусган тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор батлуулж, олон нийтэд мэдээлнэ.

2.1.6. Төрийн захиргааны байгууллага нь дараа жилд шинээр хэрэгжүүлэх ГСА-ын геологийн даалгаврын төсөлд салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, их, дээд сургуулийн саналыг авч нэгтгэн боловсруулж тухайн жилийн 10 дүгээр сарын 31-ний дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.1.7. Шинээр хэрэгжүүлэх ГСА-ын геологийн даалгаврын төслийг төрийн захиргааны төв байгууллагын геологийн асуудал хариуцсан нэгж хянан төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргаар дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор батлуулна.

2.2. Геологийн судалгааны ажлын төсөл, төсөвт тодотгол хийх

2.2.1. Төсөл гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, санхүүжилтийн хоцрогдол зэрэг шалтгааны улмаас төсөл гүйцэтгэх хугацааг сунгуулах, ГСА-ын арга аргачлал, хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх төсөл, төсвийн тодотголын саналаа жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор төрийн захиргааны байгууллагад албажуулан ирүүлнэ.

2.2.2. Төсөл гүйцэтгэгч нь тухайн жилийн ажлын арга, аргачлал, хэмжээ, төсвийн тодотгол болон шийдвэрлүүлэх саналыг ЭБМЗ-ийн худалдаанаар хэлэлцүүлэхдээ төсөл гүйцэтгэх хугацаанд хийсэн ажлын хэмжээ, гүйцэтгэл, гүйцэтгээгүй ажлын хэмжээ, дүн, гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын хэмжээ, дүн болон илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын хэмжээ, дүнг жил бүрээр гаргаж, өөрийн хүчээр гүйцэтгэсэн ажлын санхүүжилт аваагүй гүйцэтгэлийг дараа жилийн ГСА-ын төсөв, төлөвлөгөөнд оруулах саналаа энэхүү журмын 4, 5 дугаар хавсралтын дагуу хийнэ.

2.2.3. Төрийн захиргааны байгууллага нь ГСА-ын аргачлал, хэмжээ, төсөвт оруулах өөрчлөлтийн саналыг тухайн жилийн 3 дугаар сарын 01-ний дотор хянаж 4 дүгээр сарын 15-ны дотор ЭБМЗ-өөр хэлэлцүүлнэ.

2.2.4. ЭБМЗ-өөс гаргасан дүгнэлтийг үндэслэн төсөл тус бүрийн төсвийн тодотголыг 5 дугаар сарын 30-ны дотор боловсруулан сайдаар батлуулна.

2.2.5. Үргэлжлэн хэрэгжиж байгаа ГСА-ын тухайн жилийн төсвийн тодотголд тусгах үнийн тохируулгын саналыг төрийн захиргааны байгууллага боловсруулан тухайн жилийн 3 дугаар сарын 01-ний дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Тухайн төслийн төсөвт үнийн тохируулга хийх саналыг төрийн захиргааны төв байгууллага хянаж, Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлнэ.

2.2.6. ГСА-ын тухайн жилийн төсөвт батлагдсан магадлашгүй ажлын зардлын төсвийг тухайн төслийг гүйцэтгэх явцад гарсан урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд геологийн судалгааны үндсэн ажлыг санхүүжүүлэх зорилгоор зарцуулах эсэх асуудлыг хээрийн шуурхай хяналтын тэмдэглэл, гүйцэтгэгчийн гаргасан саналыг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2.2.7. Төрийн захиргааны төв байгууллага нь үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийн тухайн онд батлагдсан төсвийн тодотгол, шинээр гүйцэтгэх төслүүдийн тухайн оны гэрээний дүнг нэгтгэн боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төсөв, төлөвлөгөө”-г энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу 6 дугаар сарын 30-ны дотор боловсруулан сайдаар батлуулж Сангийн яаманд хүргүүлнэ.

2.2.8. Төрийн захиргааны байгууллага нь гүйцэтгэгчээс ирүүлсэн албан ёсны хүсэлт, шуурхай хяналтын хурлын тэмдэглэл, хээрийн ажил хүлээн авсан тэмдэглэл болон холбогдох баримт материалыг үндэслэн төслийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн нэгтгэж тухайн жилийн 11 дугаар сарын 30-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад албажуулан хүргүүлнэ.

2.2.9. Төрийн захиргааны төв байгууллага батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрийг ГСА-д бүрэн зарцуулахын тулд төслийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг тухайн онд багтаан гүйцэтгэгч нарт олгох асуудлыг хянаж сайдад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.2.10. Төрийн захиргааны төв байгууллага нь түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг зэрэг гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн, мөн урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөлийн улмаас санхүүжилт 60 хоногоос илүү хугацаагаар хоцорсон тохиолдолд ГСА-ын хугацааг талууд тохиролцон сунгана. Гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

2.3. Геологийн судалгааны ажлын гүйцэтгэл гаргах

2.3.1. Төсөл гүйцэтгэгч нь тухайн жилийн төсөв батлагдсаны дараа төсөл тус бүрийн ажлын гүйцэтгэлийг энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу үнэн зөв, алдаа,

засваргүй 3 хувь үйлдэж сар бүрийн 30-ны дотор төрийн захиргааны байгууллагад албажуулан хүргүүлнэ.

2.3.2. Гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй болохыг тухайн төсөл гүйцэтгэгч хуулийн этгээд хариуцах бөгөөд ажлын гүйцэтгэлийг худал мэдүүлж санхүүжилт авсан нь тодорхой баримт, нотолгоогоор тогтоогдвол холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага тооцно.

2.3.3. Төрийн захиргааны байгууллага төсөл гүйцэтгэгчээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж нэгтгэнэ. Ажлын гүйцэтгэлийн нэгтгэлийг төрийн захиргааны байгууллагын дарга зөвшөөрсний дараа 3 хувь үйлдэн сар бүрийн 5-ны дотор энэхүү журмын 7 дугаар хавсралтын дагуу төрийн захиргааны төв байгууллагын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжид албажуулан хүргүүлнэ.

2.3.4. Төсөл гүйцэтгэгч нь жил бүрийн ГСА-ын гүйцэтгэл, түүний зардлын задаргааг ажлын нэр төрөл бүрээр 8 дугаар хавсралтын дагуу гаргаж ГСА-ын жилийн эцсийн тайланд хавсарган төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

2.4. Геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх

2.4.1. ГСА-ын төсөв, төлөвлөгөө батлагдсаны дараа төрийн захиргааны төв байгууллага нь төслийн санхүүжилтийн хуваарийг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор боловсруулж Сангийн яаманд 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

2.4.2. Төрийн захиргааны байгууллагаас нэгтгэн ирүүлсэн сар бүрийн гүйцэтгэлийг төрийн захиргааны төв байгууллагын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгж хянаж Сангийн яаманд хүргүүлэх бөгөөд тус яам геологийн судалгааны ажлын санхүүжилтийг шуурхай хийнэ.

2.4.3. Сангийн яам нь батлагдсан төсвийн хуваарьтай уялдуулан ГСА-ын сар бүрийн гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрхийг нээх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийг ГСА-ын дансаар дамжуулан гэрээнд заасан төсөл гүйцэтгэгчийн харилцах дансанд шилжүүлнэ.

2.4.4. Төсөл гүйцэтгэгч санхүүжилтийн дансаа солисон тохиолдолд ажлын 3 өдрийн дотор төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

2.4.5. Санхүүжилтийн эрх хязгаартай нээгдсэн тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь баталгаажсан сар бүрийн гүйцэтгэлийг үндэслэн тухайн төсөлд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тооцон тодорхойлж ажлын 3 өдөрт багтаан энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу төсөл гүйцэтгэгчид хуваарилан санхүүжүүлнэ.

2.4.6. ГСА гүйцэтгэх гэрээнд заасны дагуу бэлтгэл ажлыг хангахад зориулан гүйцэтгэгч нарт урьдчилгаа төлбөрийг төслийн тухайн жилийн төсөвт өртгийн 20 хүртэл хувь хэмжээгээр олгож болно. Урьдчилгаа төлбөрийг шинэ төслийн хувьд судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулсны дараа, үргэлжлэн хэрэгжиж буй төсөлд тухайн оны эхнээс олгох бөгөөд гүйцэтгэгчээс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасны дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлсэн тохиолдолд олгоно.

2.4.7. Төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн сүүлийн жилийн төсөвт тусгагдсан өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын төсвийн 20 хувийг тайлангийн барьцаанд байлгана. Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн сайдын шийдвэр гарч Геологийн мэдээллийн төв архив (цаашид “ГМТА”)-т хүлээлгэн өгч, ГСА-ын гэрээг дүгнэсний дараа тайлангийн барьцааг буцаан олгоно.

2.4.8. Төсөл гүйцэтгэгч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон ГСА гүйцэтгэх гэрээнд заасны дагуу нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа гаргах бөгөөд гүйцэтгэлийн батлагаа гаргасан төсөлд журмын 2.4.7 дахь заалт үйлчлэхгүй.

2.4.9. Төсөл гүйцэтгэгч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилд гүйцэтгэсэн ажлын хувьтай тэнцүү хувиар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлүүлэх хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 5-р сарын 15-ны дотор гаргаж шийдвэрлүүлнэ.

2.4.10. ГСА-ын санхүүжилтийн дансны гүйлгээнд төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хариуцсан мэргэжилтэн гарын үсэг зурж, судалгааны санхүүжилтийн тайлан тэнцэл гарган бүртгэлийн хяналт тавина.

Гурав. Геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх

3.1. ГСА-ыг батлагдсан гэрээ, геологийн даалгавар, төсөлд тусгасны дагуу холбогдох заавар, түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх бөгөөд орчин үеийн шинэ техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтэт арга, аргачлалыг нэвтрүүлж ажлыг чанартай гүйцэтгэнэ.

3.2. Төсөл гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх ажил буюу геофизикийн ажил, ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон сансрын зураг, түүний тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг захиалж хэвлүүлэх болон бусад шаардлагатай ажил, үйлчилгээ, бараа материал гэх мэтийг гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

3.3. Төсөл гүйцэтгэгч нь ГСА-ын дээж, сорьцын шинжилгээг геологийн төв лаборатори болон итгэмжлэгдсэн бусад лабораторитой гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

3.4. Төсөл гүйцэтгэгч нь төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын гэрээг дүгнэж, төлбөр тооцоог бүрэн барагдуулсан баримтыг ГСА-ын үр дүнгийн тайланд хавсаргасан байна.

3.5. Геологийн даалгавраар өгөгдсөн асуудлуудыг судалгааны оновчтой шинэлэг арга аргачлал, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэж, онолын хувьд маргаантай байгаа асуудлыг шийдвэрлэх ач холбогдол бүхий баримтыг олж тогтоосон болон ашигт малтмалын хувьд хэтийн төлөвтэй эсэхийг бүрэн эцэслэн шийдвэрлэж, тайланг

хугацаанд нь амжилттай хамгаалсан гүйцэтгэгчийг төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 1 хүртэл хувь хэмжээгээр урамшуулан шагнаж болно. Шагналын хувь, хэмжээг ЭБМЗ-ийн хурлын дүгнэлтийг үндэслэн сайдын шийдвэрээр олгоно.

3.6. Төсөл гүйцэтгэгч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу төсөл бүрээр геологийн даалгаврын биелэлтийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан улирлын тайланг тухайн жилийн улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор төрийн захиргааны байгууллагад цахим болон цаасан хувиар албажуулан ирүүлнэ.

3.7. Төрийн захиргааны байгууллага нь геологийн даалгаврын биелэлтийн үр дүн, санхүүжилтийн тайланг улирал бүр нэгтгэн гаргаж, тухайн жилийн улирал бүрийн дараа сарын 5-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад цахим болон цаасан хувиар албажуулан хүргүүлнэ.

3.8. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас ГСА-ын төсөл тус бүрийн гүйцэтгэлийн явцад шуурхай хяналт хийх, хээрийн анхдагч материал хүлээн авах комисс (цаашид “комисс” гэх) болон Монголын стратиграфийн комисс (цаашид “МСК” гэх)-ийг томилон ажиллуулна. Комисс нь төсөл тус бүрийн судалгааны ажилд хяналт тавьж, маргаантай болон хүндрэлтэй асуудлыг тухай бүр судлан арга, аргачлалын зөвлөмж өгч ажиллах бөгөөд шийдвэрлэсэн асуудлын талаарх илтгэх хуудсыг удирдлагад танилцуулна.

3.9. Комиссын шуурхай хяналт, хээрийн анхдагч материал хүлээн авах, МСК-ийн зардал, хяналт тавихад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, ажлын гүйцэтгэлийг хэмжин шалгах, судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авч лабораторийн шинжилгээ хийлгэх, ГСА-тай холбоотой арга аргачлал, заавар, зөвлөмж, норм боловсруулах, үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх, ГСА-ыг үр дүнтэй гүйцэтгэж, тайланг ЭБМЗ-өөр амжилттай буюу онцсайн хамгаалсан гүйцэтгэгчийг урамшуулан шагнах зардлыг аргачлал, хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

3.10. Төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн холбоод, их, дээд сургууль, эрдэмтэдтэй хамтран салбарын боловсон хүчнийг давтан сургах, дадлагажуулах зорилгоор хээрийн болон танхимын сургалтыг зохион байгуулахад аргачлал, хяналтын зардлаас жил бүр тодорхой хэмжээний төсвийг зарцуулна.

3.11. ГСА-ын тухайн жилийн аргачлал, хяналтын зардлын төсвийг төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн төсөл тус бүрийн өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2 хүртэл хувьтай тэнцэх төсвийг төсөл гүйцэтгэгчийн санхүүжилтээс авч төрийн захиргааны төв байгууллагын ГСА-ын аргачлал, хяналтын зардлын дансанд төвлөрүүлэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батлан зарцуулах эрхийг нээнэ.

3.12. Батлагдсан аргачлал, хяналтын зардлын төсөв болон төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн холбогдох баримт, материалыг үндэслэн ГСА-ын аргачлал, хяналтын зардлын санхүүжилтийг төрийн захиргааны төв байгууллага хянан олгож зарцуулалтыг тухайн жилийн 2 болон 4 дүгээр улиралд цахим байдлаар нийтэд мэдээлнэ.

3.13. Тухайн онд шинээр хэрэгжүүлж эхлэх ГСА-ын сонгон шалгаруулалт хийгдэж гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулсны дараа төсөл хэрэгжих аймгийн Засаг даргын тамгын газар болон холбогдох төрийн захиргааны байгууллагад төслийн ач холбогдол, үр дүнгийн талаар танилцуулж, гүйцэтгэгч байгууллагыг ажиллах нөхцөлөөр хангах тухай хүсэлт, хэлцлийг төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

3.14. Төсөл гүйцэтгэгч нь ГСА-ын арга аргачлал зөрчсөн, Захиалагчтай тохиролцолгүйгээр төсөлд заагаагүй ажил гүйцэтгэсэн, шуурхай хяналтын үед илэрсэн зөрчил дутагдлыг хугацаандаа арилгаагүй, актаар оногдуулсан төлбөр торгуулийг барагдуулаагүй, төсөл хэрэгжүүлэх явцад олж авсан геологи, эрдэс баялгийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулсан, төсөл дээр ажиллаж байгаа голлох мэргэжилтнийг 3-аас дээш удаа өөрчилсөн нь ажлын чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлсэн, ГСА-ын үр дүнгийн тайланг хугацаандаа ЭБМЗ, ГМТА-д хүлээлгэн өгөөгүй тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсоох, төлбөр торгуулийг барьцаа хөрөнгөөс барагдуулна.

3.15. Хээрийн шуурхай хяналт хийх болон хээрийн материалыг хүлээн авах хяналтын хуудсыг төрийн захиргааны төв байгууллага батална.

Дөрөв. Геологийн судалгааны ажлын үр дүнг тооцох

4.1. Геологийн даалгаварт заасан хугацаанд үр дүнгийн тайланг зохиож, шинжээчийн дүгнэлт гаргуулан геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгжээр хянуулж шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр албажуулан хүргүүлснээр геологийн судалгааны ажлыг дууссанд тооцно.

4.2. Журмын 4.1-д заасан хугацаанд геологийн судалгааны ажлыг гүйцэтгэж дуусгалгүй улмаар хугацаа хэтрүүлэн үр дүнгийн тайланг ЭБМЗ-д хүргүүлсэн тохиолдолд хоцорсон хоног тутамд төсөлд зарцуулсан нийт төсөвт өртгийн 0.03%-тай тэнцүү хэмжээний алдангийг ногдуулах ба энэ тухай төрийн захиргааны байгууллага нь ГСА гүйцэтгэсэн тухай гэрээг дүгнэсэн актад тодорхой заалт оруулан төрийн захиргааны төв байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

4.3. Геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцээд засвар, өөрчлөлт хийлгэхээр буцаасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд дээрх алдангийг мөн адил тооцно.

4.4. Төсөл гүйцэтгэгчийн ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагаас шуурхай хяналтыг гүйцэтгэн төсөл зохих арга, аргачлалын дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгаж, аргачлалын зөвлөгөө өгнө.

4.5. Шуурхай хяналтын комиссын бүрэлдэхүүнд салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулж болно.

4.6. Шуурхай хяналтын үед ажлын гүйцэтгэлийг газар дээр нь холбогдох баримт материал, мэдээ, мэдээлэлтэй танилцах, хэмжилт хийх замаар баталгаажуулж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Төсөл гүйцэтгэгч нь төсөлтэй холбоотой бүх баримт материал, мэдээ, мэдээллийг комисст саадгүй үзүүлж, танилцуулах, хүргүүлэх үүрэгтэй.

4.7. Хээрийн судалгааны үед геологийн даалгаварт тусгасан асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үед шинээр тогтоосон үр дүн, баримтыг үндэслэн ажлын арга аргачлал, хэмжээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах гүйцэтгэгчийн саналыг шуурхай хяналтын комисс нь газар дээр нь хянан баталгаажуулна. Тус комисс нь тухайн төслийн ажилд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналын үндэслэл, хийх арга замыг тодорхой дурдсан илтгэх хуудас боловсруулан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Төрийн захиргааны байгууллага нь асуудлыг судалж, тодорхой шийдвэрийн төслийг бэлтгэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэр гаргуулна.

4.8. Тухайн төслийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг төсөл гүйцэтгэгчээс ирүүлсэн касс, харилцахын тайланг хавсаргасан албан ёсны хүсэлт, шуурхай хяналтын хурлын тэмдэглэл, хээрийн анхдагч материал хүлээн авсан тэмдэглэлийг үндэслэн нэгтгэж тухайн жилийн 12 дугаар сарын 10-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.9. Тухайн төсөлд хээрийн шуурхай хяналт хийх явцад болон хээрийн материал хүлээн авахад гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх гэрээ, геологийн даалгавар болон арга аргачлал зөрчсөн, хийгээгүй ажлыг гүйцэтгэлд оруулж илүү санхүүжилт авсан нь тогтоогдвол уг ажлыг нөхөн хийлгэх, ажлын гүйцэтгэлээс хасах, ажлын биет хэмжээг холбогдох зардлын хамт санхүүжүүлэхээс татгалзах, ажлыг зогсоох саналыг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.10. Төсөл гүйцэтгэгч ГСА-ыг өөрийн санаачлагаар дур мэдэн зогсоосон, олгосон хөрөнгийг зориулалт бусаар ашигласан, арга аргачлалын алдаа гаргасан, хангалтгүй гүйцэтгэсэн, ажлын үр дүнгийн тайланг зохиож ЭБМЗ-өөр хамгаалаагүй, тайланг үрэгдүүлсэн тохиолдолд уг төсөлд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг төсөл гүйцэтгэгчээр улсын төсөвт эргүүлэн төлүүлэх, 5 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтад оруулахгүй хар жагсаалтанд оруулах тухай саналыг төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.11. Төсөл гүйцэтгэгч нь ГСА-ын үр дүнгийн тайланд МСК, Редакцийн зөвлөлийн дүгнэлт гаргуулж, шинжээчээр шүүмж хийлгэн, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын холбогдох мэргэжилтнүүдээр хянуулан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж хамгаална.

4.12. Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн сайд шийдвэр гаргана. Сайдын шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг 9 дүгээр хавсралтын дагуу ГМТА-ын эрхлэгч хүлээн авч төрийн захиргааны байгууллагын асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэнэ.

4.13. Тайлан, холбогдох материалыг ГМТА-г хүлээлгэн өгсний дараа төрийн захиргааны байгууллага нь “Геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ”-г дүгнэсэн

дүгнэлт болон 10 дугаар хавсралтын дагуу нэгтгэсэн төсвийн нэгтгэлийн хамт төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж гэрээг дуусгавар болгоно.

4.14. ГМТА нь тайлан, анхдагч материалыг хүлээн авах тухай холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн авч, түүний дагуу гүйцэтгэгчээс энэхүү журмын 4.11-д заасан зүйлсийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан өөрийн архивын үйлчилгээний мөрдөх журам, зааврын дагуу бүртгэлд тусган дугаарлан баримтжуулснаар нийтийн хэрэгцээнд батлагдсан тарифт үнэлгээгээр үйлчилнэ.

--- 0 ---

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 1 дүгээр хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх
геологийн судалгааны ажлын 20... оны төсөв

/төгрөгөөр/

№	Төслийн нэр	Эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилтийн дүн	20... онд олгох төсөв
0	1	2	3	4	5
1					
2					
...					
Нийт					

Танилцсан:

... ТЗТБ¹-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Боловсруулсан:

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Тайлбар:

ТЗТБ¹ – төрийн захиргааны төв байгууллага

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 2 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх
геологийн судалгааны ажлын 20... оны төлөвлөгөө

№	Төслийн нэр, байршил, хавтгайн дугаар	Код	Эхлэх, дуусах хугацаа	Тухайн онд гүйцэтгэх ажил
0	1	2	3	4
1				
2				
...				

Танилцсан:

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗБ²-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Боловсруулсан:

... ТЗБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Тайлбар:

ТЗТБ² – төрийн захиргааны байгууллага

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 3 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр 20... онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын санхүүжилтийн хуваарь

Гэрээний дүн:
20 ... онд батлагдсан дүн:

/төгрөгөөр /

№	Төслийн нэр	20... онд батлагдсан төсөв	Олгох хэмжээ /сараар/											
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
0														
1														
2														
...														
Нийт														

Танилцсан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ТЗТБ¹-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн

... ТЗТБ¹-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн

Боловсруулсан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн
судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг
тооцох журам”-ын 4 дүгээр хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) (төслийн нэр)
төслийн 20 ... оны төсвийн тодотголын төсөл

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Биет хэмжээ	Төсөвт өртөг
0	1	2	3	4	5
1					
2					
...					
Нийт					

Танилцсан:

... компанийн захирал
/тамга/

Хянасан:

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

Боловсруулсан:

... төслийн ахлагч

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 5 дугаар хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) (төслийн нэр)
төслийн 20 ... оны ажлын арга, аргачлал, төсвийн тодотгол

ГүйцэтгэгчХХК

Гэрээний дүн: төгрөг

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Гэрээний дүн		20... оны төлөвлөгөө		20... оны гүйцэтгэл		Зөрүү		...		20... оны төсвийн тодотгол		Зөрүү		Гэрээний дүнгийн үлдэгдэл	
				Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1																			
2																			
3																			
...																			
Нийт төсвийн дүн																			

Гүйцэтгэгч:

... компанийн захирал
/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч
... төслийн ахлагч

Танилцсан

:

... ТЗТБ-ын геологийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга
... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга
... ТЗБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн
... ТЗБ-ын геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн
судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг
тооцох журам”-ын 6 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа (төслийн)
төслийн ажлын гүйцэтгэл

20... оны ... дугаар сарын 01-ээс ... дугаар сарын 30-ны өдөр хүртэл

Гэрээний дүн: төгрөг

№	Ажлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тайлант сарын гүйцэтгэл		Оны эхнээс гарсан гүйцэтгэл	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
0	1	2	3	4	5	6	7
1							
...							
Нийт							

Гүйцэтгэгч:

... компанийн захирал

/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

... төслийн ахлагч

Танилцсан:

... ТЗБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн

... ТЗБ-ын геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 7 дугаар хавсралт

БАТЛАВ: ТЗТБ-ын ТНБДарга

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын
20... оны ... дугаар сарын гүйцэтгэлийн нэгтгэл

Огноо

/Төгрөгөөр/

№	Төслийн нэр	Эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Өмнөх оны жилийн эцсийн гүйцэтгэл	20... оны төлөвлөгөө	Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажил	Хянасан
0	1	2	3	4	5	6	7
1							
...							
Нийт							

Танилцсан:

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дарга

... ТЗТБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Зөвшөөрсөн:

... ТЗБ-ын дарга

Хянасан:

... ТЗБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Нэгтгэн боловсруулсан:

... ТЗБ-ын геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн

Геологийн судалгааны ажилд зарцуулсан төсвийн зардлын тайлан

Төслийн нэр:

Гэрээний дугаар :

Гэрээний дүн: төгрөг

№	Ажлын нэр төрөл	Цалин	НДШ	Материалын зардал	Бичиг хэрэг	Сэлбэг хэрэгсэл	Томил олт	Ашиглалтын зардал	Түрээсийн зардал	Түлш шатахуун	Үндсэн хөрөнгийн элэгдэл	Тээврийн зардал	Хээрийн нэмэгдэл	Холбоо	Татвар	Гадны байгууллагын зардал	Бусад зардал	...	Нийт зардлын дүн	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	
1	Төсөл, төсөв зохиолт																			
2	АГС-ын тайлалт																			
3	Зураглал																			
4	Эрлийн маршрут																			
5	Талбайн сорьцлолт																			
6	Геохимийн судалгаа																			
7	Гидрогеологийн судалгаа																			
8	Геоморфологийн судалгаа																			
9	Геофизикийн судалгаа																			
10	Топогеодезийн судалгаа																			
11	Уулын ажил																			
12	Өрөмдлөгийн судалгаа																			
13	Сорьцлолт																			
14	Лабораторийн шинжилгээ																			
15	Суурин боловсруулалт																			
...	...																			
Нийт дүн																				

Гүйцэтгэгч:

... компанийн захирал

/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

... төслийн ахлагч

Геологийн мэдээллийн төвд тайлан, материал хүлээн авсан тухай мэдэгдэл

1. Тайлангийн нэр, хувийн дугаар:
2. Талбайн байршил:
3. Судалгааны төрөл, үе шат:
4. Тайлан зохиогч:
5. Геологийн даалгаврын хугацаа: /он.сар.өдөр/
Эхэлсэн:
Дууссан:
Өөрчилсөн:

6. Төслөөр гүйцэтгэсэн үндсэн ажил:

№	Гүйцэтгэсэн ажил	Хэмжих нэгж	Төсөл		Санхүүжилт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
0	1	2	3	4	5	6
1						
2						
...						
Нийт						

7. Тайлан хамгаалсан хугацаа:
Геологийн нэгжил ирүүлсэн:
ЭБМЗ-өөр хэлэлцсэн:
ГМТ-д хүлээлгэн өгсөн:

8. Тэмдэглэл: "....."

(ГМТ-д хүлээлгэн өгсөн тайлангийн боть, хувь, хавсралт зураг, бичвэрийн дисккийн тоо, хээрийн судалгааны анхдагч материал хүлээн авсан актын дугаар зэргийг тэмдэглэнэ)

Тайлан хүлээн авсан:

Тайлан хүлээлгэн өгсөн:

Геологийн мэдээллийн төв архивын
эрхлэгч

..... ХХК-ийн захирал

(тэмдэг)

(тамга)

Мэргэжилтэн

Ерөнхий геологич/Төслийн ахлагч

Огноо

Огноо

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын 10 дугаар хавсралт

..... (судалгааны төрөл, үе шат) (төслийн нэр)
төслийн 20 ... - 20... онд гүйцэтгэсэн ажлын төсвийн нэгтгэл

Гүйцэтгэгч ХХК

Гэрээний дүн: төгрөг

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Гэрээний дүн		20... оны гүйцэтгэл		20... оны гүйцэтгэл		20... оны гүйцэтгэл		...		Нийт гүйцэтгэл	
				Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг	Ажлын хэмжээ	Нийт өртөг
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1															
2															
3															
...															
Нийт төсвийн дүн															

Гүйцэтгэгч:

... компанийн захирал
/тамга/

... компанийн эдийн засагч, нягтлан бодогч

... төслийн ахлагч

Танилцсан:

... ТЗБ-ын геологийн асуудал хариуцсан нэгжийн дарга

Хянасан:

... ТЗБ-ын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн

... ТЗБ-ын геологийн санхүү, төсвийн гүйцэтгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн